ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ
ЦЭДЭНГИЙН ОТГОНБОРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”** | | | | | | | |
| 1. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 % | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах | Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, Боомтын захиргаа болон Санхүү хөрөнгө оруулалтын газар, Боомтын хэлтэстэй хамтран дараах ажлыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: 1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Ховд аймгийн “Булган боомтын өргөтгөл шинэчлэл хийх” төслийн ажлын ээлжилт хуралдаанд 3 удаа оролцсон. Тухай боомтын шинэчлэл хийхэд 4 хувилбарт бүтээн байгуулалтын санал боловсруулагдаж, судлагааны шатанд яваа бөгөөд ОУЭМД-ийн дагуу нэвтрэн орох цэгт ноцтой байдлын үед боомтын бэлэн байдлыг хангах болон хорио цээрийн хяналт хийхэд зайлшгүй байршуулах шаардлагатай барилга байгууламж, талбай, техник тоног төхөөрөмжийг үндэслэн мэргэжлийн зөвлөмж, саналыг дэвшүүлж, хилийн 127 дугаар багана /шинэ байршилд/-ны шилжүүлэх саналын дэмжиж ажиллаж байна.<br>2. Завхан аймгийн Тэс сумын нутагт байрлах **Арц суурь** боомтын өргөтгөл, шинэчлэл, бүтээн байгуулалтын ажлын зураг төслийг гүйцэтгэж буй Дукат ХХК-иас ирүүлсэн зураг төсөлд судлаж 4 саналыг тусгуулахаар хүргүүлсэн.Үүнд:<br>- Хилээр нэвтэрч буй зорчигчдод Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдах | 2024.01.02-2024.06.05 | 50 % |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед хариу арга хэмжээг авах түр тусгаарлах өрөөг дэглэм урсгалын дагуу төлөвлөх;<br>- Ерөнхий төлөвлөгөөний барилга байгууламжийн тодорхойлолт хэсэгт мал амьтны хорио цээрийн байгууламж, шатамхай бодисын агуулахыг тодотгон тусгах;<br>- Гүний худаг, ус хангамжийн системийн хамгаалалтын бүсийг зурагт тусгах;<br>- Бохир усны системийн цооног, хэсгийн цэвэршүүлэх байгууламж, саарал ус ашиглах нөхцлийг зурагт тусгах;<br>3. Боомтын хөгжлийн хэлтсээс 2023.01.12 -ны өдрийн №09 тоот дотоод зурвас /Эн Би Си Си ХХК-иас Цагаан дэл Уул хилийн боомтын танилцуулга/ -ыг судлаж байна.<br>4. **Ханги боомтын** ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг дагалдуулж ирүүлсэн бичиг баримтыг судлаж танилцахад Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 379 дугаар тогтоол, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/6 дугаар тогтоол, Хилийн боомтын захиргаа болон Ханги эко логистик ХХК-тай байгуулсан 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн № 52 дугаартай "Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт орших хилийн Ханги боомтод гаалийн хяналтын бүс, олон төрөлт чингэлэг тээврийн терминал бүтээн байгуулж, үйл ажиллагаа эхлүүлэх гэрээ", "Ханги хилийн боомтод олон төрөлт чингэлэг тээврийн ухаалаг систем нэвтрүүлэх төсөл"-ийн танилцуулга, терминалын төлөвлөлтийн схем зураг болон төслийн бэлтгэл ажлын хүрээнд гаалийн байгууллагын холбогдох газар, хэлтсийн албан хаагчдтай уулзалт зохион байгуулсан 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэл зэрэг холбогдох баримт бичгийн бүрдэлтэй байна.<br>Ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зарчмын хувьд дэмжин, гаалийн хорио цээрийн чиглэлээр нэмэлтээр тусгах саналгүй болохыг дотоод зурвасаар хариуг хүргүүлсэн.<br>5. Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ээлжит хуралд **Булган боомт** шинэчлэлт, төлөвлөлт болон Бичигт-Зүүн хатавч боомтыг замын холболт /4 эгнээг 6 эгнээ болгох/, Сүмбэр-Рашаант боомтын гүүрэн байгууламжийн сэргээн засварлалт хийх асуудалд ОУЭМД-ийн дагуу хилийн нэвтрэн орох цэгт ноцтой байдлын үед боомтын бэлэн байдлыг хангах болон хорио цээрийн хяналт хийхэд зайлшгүй шаардлагатай барилга байгууламж, талбай, техник тоног төхөөрөмжийг үндэслэн төлөвлөх, байгаль орчны үнэлгээг хийлгэх /цэвэр, бохир усны систем/ зэрэг 2 саналыг дэвшүүлж, гарсан шийдвэрийг дэмжиж оролцсон.<br>6. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/132 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны ажлын хэсгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Сэлэнгэ аймаг дах Алтанбулаг боомт, Увс аймгийн **Боршоо хилийн боомтуудад** халдваргүйжүүлэлтийн байгууламжийг барьж байгуулах нээлттэй тендерийн холбогдох материалд “Хилийн боомтын нэвтрэн орох цэгт автотээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгавар”-ын төслийг боловсруулж, боомтын хэлтэст хариуг №93, №177 дотоод зурвас, хавсралтаар хүргүүлсэн.<br>7.Сэлэнгэ аймаг дах **Алтанбулаг боомтод** халдваргүйжүүлэлтийн байгууламжийг барьж байгуулах нээлттэй тендерийн холбогдох материалд “Хилийн боомтын нэвтрэн орох цэгт автотээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар”-ын төслийг боловсруулах явцад Сэлэнгэ аймгийн гаалийн газрын удирдлага, Хилийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 0101 дүгээр ангийн захирагч, тус боомтын захиргааны удирдлага, Монкон ХХК-уудаас ирүүлсэн /байрших газар, дэд бүтцийн талаархи/ мэдээллийн зөрүүтэй байдлаас үүссэн асуудлыг Хилийн боомтын захиргаанд танилцуулж, 2024 оны 03 сарын 28-ны өдөр холбогдох байгууллагуудын хамтарсан өргөтгөсөн хуралдаанд боомтын хэлтэстэй хамтран оролцож, мэргэжлийн саналыг зөвшилцөж, ерөнхий төлөвлөгөөний зургийн дагуу боомтын нэвтрэн орох хэсэгт зорчигчийн болон ачаа тээврийн халдваргүйжүүлэлтийн байгууламжийг тус тусд барьж байгуулан хорио цээрийн бүсийн зохион байгуулалттай байх шийдвэр гаргуулан ажилласан.<br>8. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 2023 оны 05 дугаар сараас эхлүүлсэн **“Шивээ хүрэн-Сэхэ боомтын** төсөл”-ийг хэрэгжүүлэгч “Нарийн сухайтын төмөр зам” ХХК-ийн бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцаж, зураг төслийн баримт бичгийн зөвшилцөх /эрүүл ахуй, ариун цэврийн төлөв байдалд/ ажлын хүрээнд 5 саналыг хүргүүлсэн. Үүнд:<br>- Ус хангамжийн системийн /гүний худаг/, хамгаалалтын бүс болон нөөцлөх сав, усны чанарыг сайжруулах нэмэлт төхөөрөмж зэргийн байгуулалтын зураг болон тайлбар бичгийг ажлын зурагт тусгах;<br>- Бохир усны системийн цооног, хэсгийн цэвэршүүлэх байгууламж, саарал ус ашиглах нөхцлийн талаар байгуулалтын зураг болон тайлбар бичгийг ажлын зурагт тусгах;<br>- Гааль, хил хяналтын байгууллагын ажилчдын амьдрах сууцыг төлөвлөх;<br>- Ажлын байрны хүрэлцээг / одоогоор 7 орон тоо/ нэмэгдүүлэх;<br>- Хилээр нэвтэрч буй зорчигчдод Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдах халдварт өвчний сэжигтэй тохиолдол | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | илэрсэн үед түр тусгаарлах өрөөг дэглэмийн дагуу төлөвлөх;<br>9. МУЗГ, БСҮХороо, Хилийн боомтын захиргаа, МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулсан **“Боомтын сэргэлт үндэсний форум 2024”** үйл ажиллагаанд оролцсон. | | |
| 2. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 % | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах барааны техникийн зохицуулалт, стандарт, журам, дүрэм боловсруулах, бодлого төлөвлөлт, эрх зүйн зохицуулах, худалдааг хөнгөвчлөх, экспортын дэмжих, цахимжуулалт, боомтын хөгжил зэрэг асуудлаар холбогдох төрийн захиргааны болон дээд шатны байгууллагаас томилсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллана. | **Дээд шатны байгууллагаас томилогдсон ажлын хэсэг:**<br>1. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын дэд (чихрийн агууламж орсон хийжүүлсэн болон хийжүүлээгүй амтат ус, ундаанд онцгой албан татвар ногдуулах санал, дүгнэлтийн төсөлд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх) хэсгийн бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж байна.<br>**Эрх зүй баримт бичгийн шинэчлэх, боловсруулах ажлын хүрээнд**: /Санал/<br>1. “Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэх журам”-ын төсөлд ажлын хэсгийн багаар ажиллаж санал солилцож, зөвшилцөж ажилласан.<br>2. Хорио цээрийн чиглэлээр “Барааг буцаах, устгах заавар”-т 2 саналыг боловсруулан өгсөн.<br>3. Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос ирүүлсэн Хил хамгаалах ерөнхий газрын шинэчлэн боловсруулж буй “Хилийн боомтод мөрдөх нийтлэг журам”-ын төсөлд санлыг хавсралт хүснэгтээр хүргүүлж байна.<br>4. Засгийн газрын тогтоолоор шинэчлэгдэн батлагдах “Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд гаалийн хорио цээрийн хяналтын чиглэлээр 6 саналыг өгч, нэгтгэн хавсралтаар хүргүүлэв.<br>5. Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/458 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчид цол, олгох, хураах, сэргээх, цолны нэмэгдэл хөлс олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд 1 саналыг өгсөн. | 2024.01.02-2024.06.05 | 50 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 6. Хилийн боомтын тухай хуулийн төсөлд 3 санал;<br>7.“Улсын хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд зорчигч, тээврийн хэрэгсэл, бараанд халдваргүйжүүлэлт хийх журам”-д холбогдох 18 саналыг өгсөн.<br>8. Зорчигчийн эрүүл мэндийн тандалтын хүрээнд “Эрүүл мэндийн асуулга хуудас”-ыг шинэчлэн боловсруулах, цахим бүртгэлд нэвтрүүлэхэд бэлтгэх ажлыг гүйцэтгэж байна. | | |
| 3. | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 % | Хорио цээрийн үйл ажиллагааг цахимжуулах А/62 ажлын хэсгийн хүрээнд Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах барааг шалгах 10 хяналтын хуудсыг цахимжуулж, бүтээгдэхүүнээр ангилан заавар боловсруулах. | Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/115 дугаартай “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем”-ийг гаалийн автоматжуулсан мэдээллийн системтэй уялдуулан хөгжүүлэх ажлын даалгавар гаргах, ажлын төлөвлөгөө боловсруулах, туршилт хийх, нэвтрүүлэх хүлээн авах ажлын хэсэгт томилогдон ажиллаж байна.<br><br>-“Хорио цээрийн цахим хяналтын систем”-д түр тусгаарлалтын үйл ажиллагааг цахимжуулах ажилд саналыг хүргүүлсэн.<br>-Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр А/62 дугаар тушаал “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 4 систем дээр 6 модулийн хөгжүүлэлт;<br>- Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтанд хамрагдах барааны жагсаалтын HS коды шалгуур үзүүлэлтийг шинэчлэн ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу барааны ангилал, зориулалтыг HS кодоор гаргах ажлыг хийж гүйцэтгэв. | 2024.01.02-2024.06.05 | 50 % |
| **Зорилт 2. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | | |
| 4. | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Газар, хороодын халдваргүйжүүлэлт | 2024 онд барьж байгуулах Сэлэнгэ аймаг дах Алтанбулаг боомтын өнөөгийн нөхцөл /дэд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тохирлын хяналт, шалгалтын чиглэлээр дэд бүтцийг чадавхжуулсан байдал | | 100 % | ийн байгууламжийн өнөөгийн судалгааг гаргаж, 2024 онд төлөвлөгдсөн халдваргүйжүүлэлт ийн байгууламжийн ажлын даалгаварт саналыг өгч, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана. | бүтэц, эдэлбэр газар, байршил/ байдлыг газар дээр нь танилцаж, удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлсэн.<br>Увс аймгийн Боршоо хилийн боомтын бодит нөхцөл байдлын судалгааг халдваргүйжүүлэлтийн байгууламжийг барьж байгуулах нээлттэй тендерийн холбогдох материалд “Халдваргүйжүүлэлтийн байгууламжийн техникийн нөхцөлийн тодорхойлолт” болон зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулж, тендерийн хорооны ажлын хэсэгт хүргүүлэн, бичиг баримтын бүрдэлд оруулан ажилласан.<br>2025 онд шинээр барьж байгуулах Бичигт хилийн боомтын боомтын хөгжлийн хэлтэс, боомтын удирдлагатай хамтран хийж байна. | 2024.01.02-2024.06.05 | 50 % |
| 5. | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт,шалгалт хийсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 % | 1. Улсын хилээр нэвтрүүлж буй бараанд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах<br>2. Гаалийн хилээр нэвтрүүлсэн бараа, тээврийн хэрэгслэлд урьдчилан сэргийлэх болон зориулалтын халдваргүйжүүлэлт хийсэн мэдээнд дүн шинжилгээ хийнэ | 1.Тайлангийн хугацаанд хяналт шалгалтын явцад эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр зөрчил илрээгүй.<br>2. Гаалийн газар хороодоос 2024 оны нэгдүгээр улирлын байдлаар улсын хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгсэлийн урьдчилан сэргийлэх болон зориулалтын халдваргүйжүүлэлт хийсэн мэдээг хүснэгтийн дагуу авч, дүн шинжилгээ хийхэд Улсын хилээр орсон 270639 тээврийн хэрэгсэл (онгоц 1074, вагон зүтгүүр 1963, суудлын вагон 320, ачааны вагон 132195, суудлын машин 123745, ачааны машин 186897)-д урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх явцад хяналт тавьсан байна.<br>Улсын хилээр гарсан 404193 тээврийн хэрэгсэл (1074 онгоц, 1947 вагон зүтгүүр, суудлын вагон 320, 128541 ачааны вагон, 124675 суудлын машин, 251473 ачааны машин)-д хяналт тавьж ажилласан байна.<br>Түүнчлэн БНХАУ-ын талаас тавьж буй шаардлагын дагуу тус улстай хиллэж буй хилийн боомтуудад гарах чиглэлийн хөдөлгөөнд халдваргүйжүүлэлт хийн, хяналт тавьж ажилласан байна | 2024.01.02-2024.06.05 | 50 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мэдээллийг хэлтсийн удирдлагад танилцуулж ажиллалаа. Гаалийн хилээр нэвтрүүлсэн бараа, тээврийн хэрэгслэлд урьдчилан сэргийлэх болон зориулалтын халдваргүйжүүлэлт хийсэн мэдээнд дүн шинжилгээ хийсэн. | | |
| | | | | 3. Салбарын хууль тогоомжийг боловсронгуй болгох талаар бусад байгууллагатай хамтран ажиллах | 3. -БНХАУ-ын Эрээн хотод 2024 оны 05 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Хилийн эрүүл ахуй, хорио цээрийн хамтын ажиллагааны протокол"-ын хэрэгжилтийн ажлын хэлэлцээрд ГЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/249 дугаар тушаалын дагуу ХЦХ-ээс 3 төлөөлөл, ЗӨСҮТ-ийн 2 төлөөллийн хамт оролцож, зоонозын халдварын хил дамнах эрсдэлээс сэргийлэх, хяналт тандалт хийх 2024-2027 оны төлөвлөгөөг БНХАУ-Хөх хотын Гаалийн газар, Өвчин судлалын төв, Эрээн гаалийн газар, ЗӨСҮТ-тэй хамтран батлав.<br>- Дэлхийн банкны чихэрлэг ундааны экспертүүд, ажлын хэсэг хамтарсан "Чихэрлэг ундааны татварыг хэрэгжүүлж буй олон улсын туршлага, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, хэрэгжилтэд анхаарах асуудал" сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон. Ажлын хэсгээс Монгол Улсад чихэрлэг ундааны татварыг хэрэгжүүлснээр хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн судалгааны үр дүнг танилцуулж санал солилцов.<br><br>**Хүрсэн үр дүн:**<br>Бараа, тээврийн хэрэгсэлд тавих эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын хэрэгжилт хангагдаж байна<br>Бараа, тээврийн хэрэгсэлд тавих эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын хэрэгжилт хангагдаж байна | | |
| 6. | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 % | 1. Улсын хилээр нэвтэрч буй зорчигчдод | **1.** Улсын хилээр нэвтэрч буй зорчигчдод тавигдаж буй хяналт тандалтын мэдээг гаалийн газар хороодоос нэгдүгээр улирлын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангасан байдал | | | тавигдаж буй хяналт тандалтын мэдээг нэгтгэн газрын удирдлага, холбогдох газруудад хүргүүлэх.<br><br>2. Халдвараас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд Гаалийн газар, хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах. Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005)-ийн үндэсний зохицуулагч байгууллага (ХӨСҮТ)-тэй гаалийн хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгсэл барааны мэдээллийг (өдөр тутмын болон үйл явдлын) солилцох эрх зүйн орчинг бий болгож, цахимаар солилцох нөхцөлийг бүрдүүлэх. | байдлаар өссөн дүнгээр хүснэгтийн дагуу авч, дүн шинжилгээ хийхэд Монгол Улсын хилээр орсон 1,055965 (дотоод 825084, гадаад 230881), улсын хилээр гарсан 986931 (дотоод 822908, гадаад 164023) зорчигчдод сэжигтэй тохиолдол илрээгүй байна. Мэдээллийг хэлтсийн удирдлагад танилцуулж ажиллалаа.<br>2. Халдвараас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 28 тушаалын "Болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын үед олон эх сурвалж ашиглан салбар хооронд мэдээ, мэдээлэл солилцох журам"-д заасны дагуу халдвараас сэргийлэх, сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах хариу арга хэмжээг хэрэгжүүлэх талаарх асуудлыг тэргүүлэх чиглэлийн байгууллага ХӨСҮТ-ийн тандалт судалгааны албатай хамтрах ажиллаж байна.<br>**Хүрсэн үр дүн:**<br>Гаалийн газар, хороодын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчдад нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд болон улсын хилээр нэвтрүүлэх зорчигчдод халдвараас сэргийлэх хяналт тавих үйл ажиллагаанд мэргэжлийн удирдлагаар хангаж, зөрчилгүй ажиллаж байна. | 2024.01.02-2024.06.05 | 50 % |
| 7. | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд тавьсан хяналт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 % | Гаалийн харьяа газар хороодын салбар лаборатори болон бусад | Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтаар лабораторийн шинжилгээнд 42 аж ахуйн нэгжийн 207,4 мян.тонн бараанаас 103 нэр төрлийн 0,41 тн, 0,01 мян.доллор, 554.4 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | итгэмжлэгдсэн лабораториийн шинжилгээнд хамрагдсан бараа (гоо сайхан, ахуйн химийн бараа, хүүхдийн тоглоом, архи согтууруулах ундаа, тамхи, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн гэх мэт) -ны мэдээг сар бүр авч, ээрэг гарсан сорьцонд дүн шинжилгээ хийн, удирдлагын мэдээллээр хангаж ажиллана. | төгрөгийн дээжийг чанар, аюулгүй байдлын үзүүлэлтээр 223, бусад 17 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулахад, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан тул хилээр нэвтрүүлэн ажилласан байна.<br>2024 оны 1 дүгээр улиралд экспортын мэдээгээр Эрүүл ахуйн хяналтын чиглэлээр нийт 69 аж ахуйн нэгж, 51 иргэн экспортолсоноос мэдүүлэгээр 108, ангилалтын тоо хэмжээгээр 5,8277 мян.тн, 4 мэдүүлэгээр 28литр, 10 мэдүүлэгээр 341036 ширхэг бараа экспортлогдсон. Барааны цэвэр жин 12,87 мян.тн, бохир жин 14,92 мян.тн, 4,7 мян.доллар, 119528,46 төгрөг байна.<br>Импортын мэдээгээр нийт Эрүүл ахуйн хяналтын чиглэлээр хяналтад хамрагдсан нийт 35190 аж ахуйн нэгж, 6187 иргэн импортлогдсоноос мэдүүлэгээр 41377, ангилалтын тоо хэмжээгээр 95,2 мян.тн импортлогдсон. Барааны цэвэр жин 34,0 мян.тн, бохир жин 135,9 мян.тн, 69,5 мян.доллар байна. | 2024.01.02-2024.06.05 | 50 % |
| 8. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 % | Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллана. | 1. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам -ыг үндэслэн "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах мэдээлэл цуглуулах асуулгын хуудас"-аар Гаалийн ерөнхий газар болон харьяа газар хороодын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нараас саналыг авч, дүн шинжилгээ хийн "Албан тушаалын тодорхойлолтын маягт"-ын дагуу "Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэл хариуцсан гаалийн улсын байцаагч нарын ажлын байрны тодорхойлолт"- ын төслийг /нийт 2/ боловсруулан хэлтсийн удирдлагад танилцуулж ажилласан.<br>2. Хүний нөөцийн хэлтсээс 2023.01.19-ний өдрийн №21 тоот дотоод зурвас / эрүүл ахуй халдвар хамгааллын хяналт болон хүнсний | 2024.01.02-2024.06.05 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чанар стандартын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч нарын нэгтгэсэн албан тушаалыг зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэх батлуулахтай холбоотой судалгааг хийж, нэгтгэсэн.<br>3. 2024.05.03 №68 СХОГ-аас Бичигт хилийн боомтод шаардлагатай хорио цээрийн болон ариутгал халдваргүйжүүлэлттэй холбоотой тоног төхөөрөмжүүдийн жагсаалт, техникийн үзүүлэлт, тоо хэмжээ, үнийн дүн зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ үү<br>3. Хорио цээрийн хэлтсийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шуурхай хурлаас удирдлагаас өгсөн үүргийн дагуу шуурхай удирдлагын төвийн 1281 дугаарын лавлах утсанд хорио цээрийн хяналтын чиглэлээр түгээмэл ирдэг асуултанд мэдээлэл өгөх зааварчилгааг эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр нийт 5 асуулт, хариултыг боловсруулж ажилласан.<br>3. Гаалийн газар, хороодоос 2024 оны эхний хагас жилийн байдлаар хөдөлгөөний болон тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн мэдээг авч нэгтгэв.<br>4. ГЕГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг хилийн боомтод ажиллах удирдамжийн дагуу 2024 оны 04 сарын 14-ний өдөр хүртлэх хугацаанд Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг хилийн боомтод хийгдэж буй өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалтын ажлын явцтай холбогдох байгууллагуудтай хамтран газар дээр нь ажиллаж, ачаа болон зорчигч тээврийн халдвар байгууламжийн барилгын газар, байршилыг тогтоох, салбар лабораториудын барилгын ажлын зураг, тухайн ажлын байрны техникийн болон эрүүл ахуйн нөхцөл шаардлагын дагуу хийлгэх талаар санал солилцох зэргээр зөвшилцөж, ГЕГ-ын удирдлагад танилцуулж тухайн байгууламжийг бариулах шийдвэрийг гаргуулаад байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 5. - Барилга хот байгуулалтын яамнаас ирүүлсэн 02/1154 дугаартай “Хамтран ажиллах тухай” албан бичгээр нийт 13 нэр төрөл барилгын материалыг хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохиролын хяналтад хамруулах шаардлагатай талаар ирүүлсэн хүсэлт болон Монгол Улсын барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 117 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгээс гарсан шийдвэр /Монгол Улсын зах зээлд нийлүүлэгдэж байгаа импортын барилгын материалын чанарт ахиц гаргах, барилгын материалын хилийн хяналтыг сайжруулах, “ИМПОРТЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН СТАНДАРТ” хэлэлцүүлгээс гарсан санал /13 нэр төрлийн барилгын дотоод заслын материалыг хилийн хяналт, лабораторийн шинжилгээнд хамруулах/-ыг үндэслэн “ЭРСДЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮСЭЛТ” -ээр нийт 13 нэр төрлийн 48 бараанд барааны нийт ачилтын 60 хувьд өндөр эрсдэлийн шалгуурт /бараанд болон бичиг баримтын шалгалт/ хамруулах, улирлын чанартай импортлогддог тул IV-X дугаар сар хүртэл өндөр эрсдэлийн шалгуураар бусад үед санамсаргүй сонголтоор шалгах боломжтойгоор http://cais.ecustoms.mn/ гаалийн автоматжуулсан удирдлагын системд оруулах саналыг боловсруулж, Эрсдэлийн удирдлагын хэлтэст №146 дугаартай дотоод зурвасаар хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br>6. Хэлтсийн дотоод ажил үйлчилгээний хуваарийн дагуу Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагад илгээсэн болон тухайн байгууллагуудаас ирүүлсэн дотоод зурвасыг бүртгэх, архивт өгөх ажлыг хариуцан ажиллаж байна. /дотоод зурвас ирсэн-81, явсан-110 /<br>**Олон нийтийн ажилд**: | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1. “Гаалийн цом 2024” спорт тэмцээнд оролцож мөнгөн медаль хүртсэн.<br>2.Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Сургалтын төвөөс зохион байгуулсан “Гаалийн мэргэшил ба эмэгтэйчүүд” уулзалтанд оролцсон.<br>3. **Хүрсэн үр дүн:**<br>Хугацаа хоцроосон үүрэг даалгаврын биелэлт байхгүй байна. | | |
| 9 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 % | 1.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | 1.Тайлангийн хугацаанд: ирсэн 19 албан бичгийг хүлээн авч, 6 албан бичгээр хариуг хүргүүлж, 13 албан бичгийг мэдээллийн санд бүртгэж, 1111 тусгай дугаарт ирсэн 1 өргөдөл гомдол шийдвэрлэж https://edoc.ecustoms.mn/ цахимд бүртгэгдсэн байна.<br>**Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:**<br>Иргэн Төмөр Очирийн 1111 төвд 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн “хүүхдийн гоёл чимэглэлд хэрэглэж буй шүр сувд нь химийн хорт бодис хлороформ агуулсан, материал нь хуванцар, хүүхэд толгойдоо зүүхэд арьс салстаар цочирол өгдөг энэ зүйл хяналтгүй байна “ гэсэн мэдээлэл нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяаллын дагуу 6.11 дэх заалтад тусгагдсан гаалийн улсын байцаагчийн хамаарах зөрчил биш тул Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын дагуу Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газарт хандах нь зүйтэй гэж мэргэжлийн зөвлөгөө өгч, Шуурхай хяналтын төвд №60 Дотоод зурвасыг хүргүүлсэн.<br><br>**Албан бичгийн шийдвэрлэлт**<br>Ирсэн бичиг: 13<br>Явсан бичиг: 7<br>Төрийн байгууллагад:<br>-Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 02/772 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. | 2024.01.02-2024.06.05 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Ариун гэгээ гоо ХХК, Винтрий ХХК, Лэмиссер ХХК, Сүндэр хөрөнгө оруулалт групп ХХК, Хаан Пилсенер ХХК, Эн Эс Партнерс ХХК, Парфлюкс ХХК, Халифа ХХК -иас ирүүлсэн хүсэлтийн дагуу 8 нэр төрлийн согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлыг тодорхойлох зорилгоор дээж авч, Гаалийн ерөнхий газрын төв лаборатори, Хүнсний аюулгүй байдал үндэсний лавлагаа лабораторид шинжилгээнд хамруулж, 8 албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас ирүүлсэн болон дотоод зурвас болон хэлтсээс явсан дотоод зурвасыг архивын нэгж болгон бэлтгэж байна<br>**Хүрсэн үр дүн:**<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган зөрчил, дутагдалгүй ажилласан байна. | | |
| | | | | 2.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад | 2. Монгол Улсын засгийн газрын 2023 оны 08 дугаарын 23-ны өдрийн 301 дугаар тогтоолоор батлагдасан “Журам шинэчлэн батлах тухай” нэгдүгээр хавсралтын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нийт 2 зорилт, 15 арга хэмжээг боловсруулж, хэлтсийн даргаар батлуулан, биелэлтийг ханган ажиллаж байна.<br>**Хүрсэн үр дүн:**<br>2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулж биелэлтийг хханган ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | |
| 10. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | Ажлын цагийг үр дүнтэй ашиглаж, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах. | 2024 оны 1, 2, 3 дугаар сард нийт 64 хүн/ өдөр ажилласан байна.<br>**Хүрсэн үр дүн:**<br>Тайлангийн хугацаанд тасалсан, өвчтэй, чөлөөтэй цаг байхгүй. | 2024.01.02-2024.06.05 | 50% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 11. | Арга хэмжээ 1. Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасны дагуу өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 % | 25% | 1. ХӨСҮТ--ийн Талбарын тархвар судлалын албанаас зохион байгуулах “Талбарын тархвар судлалын анхан шат”-ны мэргэжил дээшлүүлэх 2 сарын 12.5к багц сургалтад эрүүл ахуй халдвар хамгааллын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч /ДоГГ-1, Замын Үүд дэх ГГ -1/ 2 албан хаагчийг хамруулахаар мэдээллийг 2024.05.29 өдрийн 02-1.2/2119 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>**Мэдлэг ур чадвараа дээшлүүлэхэд:** Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ДГБ-ын зөвлөлүүдийн хамтарсан | 2024.01.02-2024.06.05 | 25 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөр (AEO)” -ийг сайжруулах, тогвортой болгох үндэсний семинарт оролцож **сургагч багш-**ийн гэрчилгээг гардан авсан.<br>**Танхим сургалт, мэдээлэлд:** Захиргааны удирдлагын газраас зохион байгуулсан мэдээллийн цагт хамрагдсан.<br>ОНХА-нд согтууруулах ундаанд тавих хорио цээрийн хяналт сэдвээр мэдээлэл өгсөн.<br>Хорио цээрийн хэлтсээр зохион байгуулсан олон нийтийн мэдээллийн цаг хамрагдсан.<br>Мэдээллийн цагт сууж, цаг үеийн мэдээ, мэдээлэл сонсож байна<br>**Цахим сургалт:** Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” цахим сургалт хамрагдаж, санхүүгийн боловсролын түвшинг дээшлүүлэх, хуримтлуулах ач холбогдлын талаар мэдлэгтэй болсон. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Гаалийн улсын байцаагч
*( Албан тушаал )*

.................................. / Ц.Отгонбор/
*( Нэр, гарын үсэг )*

2024.06.10
*( Огноо )*

1926

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Ц.ОТГОНБОРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хорио цээрийн хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 58 | 10 | 68 | |
| 2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 56 | 8 | 64 | |
| 3 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлсэн байдал | 56 | 8 | 64 | |
| **Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын чиглэлээр дэд бүтцийг чадавхжуулсан байдал | 57 | 10 | 67 | |
| 2 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт,шалгалт хийсэн байдал | 58 | 10 | 68 | |
| 3 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангасан байдал | 58 | 10 | 68 | |
| 4 | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд тавьсан хяналт | 57 | 10 | 67 | |
| 5 | Үүрэг даалгаврын биелэлт | 59 | 10 | 69 | |
| 6 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 59 | 10 | 69 | |
| 7 | Ажлын цаг ашиглалт | 59 | 10 | 69 | |
| **Дундаж оноо:** | | | | 65 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасны дагуу өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж ажиллах | 90 % | 14 | |
| Дундаж оноо: | | | 14 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 6 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 6 | |
| | **Дундаж оноо:** | **6** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 |
| 2 | Багаар ажиллах | 7 |
| 3 | Харилцаа | 7 |
| | | **Дундаж оноо: 7** |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *65* |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *14* |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | **6** |

| | | |
|---|---|---|
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | 7 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =92**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Хорио цээрийн хэлтсийн дарга .......................................... (Г.Батмөнх)

2024.06.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч Ц.Отгонбор (Ц.Отгонбор)

2024.06.10 (огноо)

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................ (Г.Энхтайван)

2024.07.26 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................ (Ж.Баясгалан)

..................... (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга ............................ (Р.Отгонжаргал)

.................................(огноо)